

  
МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/347

Улаанбаатар хот

Г Тэргүүлэх чиглэл, ажлын хэсгийн  
бүрэлдэхүүнийг батлах тухай Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.4, Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам”-ын 5.2, 5.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/598 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл (2020-2025)”-ийн 2 ба 5 дугаар хэсэг, 2024 оны А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Монгол улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.”Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)”-ийг нэгдүгээр, Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах ажлын хэсгийг хоёрдугаар, ажлын хэсгийн ажлын удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлд нийцүүлэн төрөлжсөн мэргэшлийн төв болон нэгдсэн эмнэлэг, бусад байгууллагаас төсөл, арга хэмжээний захиалгын саналыг цуглуулах, шалгаруулахыг Ажлын хэсгийн дарга (Б.Нарантуяа)-д, эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төслийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг мэдээллээр хангах, шалгарсан төсөл, арга хэмжээний танилцуулгыг яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн хуралд танилцуулахыг Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн Нарийн бичгийн дарга (Д.Ганзориг)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Гэрэлмаа)-д даалгасугай.

САЙД



Т. М. С.

Т.МОНХСАЙХАН

141241704

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08  
дугаар сарын 13. -ны өдрийн 13:47  
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэй технологи нэвтрүүлэх үйл  
ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)

- 1.1. Зүрх, тархины судасны тогтолцооны эмгэг
- 1.2. Хорт хавдар
- 1.3. Гэмтэл, согог
- 1.4. Хүний геномикс/удамшлын эмгэг
- 1.5. Сэтгэц мэдрэлийн өвчин

---oOo---

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08  
дугаар сарын 13. -ны өдрийн 13/14  
дугаар тушаалтын хоёрдугаар  
хавсралт

Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд дэвшилтэй технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Дарга:

Б.Нарантуяа,  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал

Нарийн бичгийн дарга:

Д.Ганзориг,  
Эрүүл мэндийн яамны Салбарын эрдэм шинжилгээ, судалгаа төлөвлөлт хариуцсан шинжээч,

Б.Отгончимэг,  
Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Хүний нөөцийн хөгжлийн албаны дарга

Гишүүд:

С.Сүхбат,  
ЭМЯ-ны дэргэдэх Гэмтэл, согог судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн Ерөнхий мэргэжилтэн

Ө.Цолмон,  
ЭМЯ-ны дэргэдэх Дотрын анагаах судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

С.Батболд,  
ЭМЯ-ны дэргэдэх Эх барих, эмэгтэйчүүд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Бумдэлгэр,  
ЭМЯ-ны дэргэдэх Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

Д.Ганбат,  
ЭМЯ-ны дэргэдэх Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

Г.Эрдэнэтуюя ,  
ЭМЯ-ны дэргэдэх Хүүхэд судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

Л.Ганбаяр,  
ЭМЯ-ны дэргэдэх Хавдар судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн

---оОо---

Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08  
дугаар сарын 13.-ны өдрийн 12:42  
дугаар тушаалын гуравдугаар  
хавсралт

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх  
төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах  
ажлын хэсгийн ажлын удирдамж

Нэг. Үндэслэл:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (19 дүгээр зүйл)-ийг дагалдан гарсан Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын 5.3, 5.6-д байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл оролцсон ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологи шинээр нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааны захиалгын саналд үнэлгээ, эрэмблэлт, сонгон шалгаруулалт хийлгэхээр заасан. Түүнчлэн "Монгол улсад эмчлэх боломжгүй өвчиний жагсаалт"-ыг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан байна.

Хоёр. Зорилго:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааг сонгон шалгаруулах

Гурав. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

Ажлын хэсэг дараах байдлаар ажиллана.

1. Эрүүл мэндийн яамны Мэргэжлийн салбар зөвлөл болон бусад эрүүл мэндийн байгууллагууд (сонгон шалгаруулалтад оролцогчид)-аас ирүүлсэн дэвшилтэт технологийн төсөл, арга хэмжээний захиалгын саналуудыг Засгийн газрын 2024 оны 78 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын 5.4-т заасан чиглэл тус бүрээр ялгана.
2. Дэвшилтэт технологийн төсөл, арга хэмжээний захиалгын санал нь энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)-д нийцсэн эсэх болон Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/273 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Монгол улсад эмчлэх боломжгүй өвчиний жагсаалт"-д дурдсан өвчин эмгэгийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн эсэх, төсөл, арга хэмжээ нь төрөлжсөн мэргэшлийн төв эмнэлэг, нэгдсэн эмнэлэгт хэрэгжих боломжтой эсэх, эрүүл мэндийн салбарт үзүүлэх ач холбогдол зэргээр эрэмбийг үүсгэн жагсаана.
3. "Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам"-ын 5.4-т заасан чиглэл тус бүрт эрэмбийн эхэнд жагссан төсөл, арга хэмжээг эцсийн танилцуулгад оруулна.

Дөрөв. Хугацаа:

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2024 оноос нэвтрүүлэх дэвшилтэт технологийн төсөл, үйл ажиллагааны танилцуулгыг 2024 оны 09 дүгээр сарын эхний хагаст багтаан яамны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлд хүргүүлнэ.

Тав. Хүлээгдэж буй үр дүн:

Төсөл, арга хэмжээний эрэмбийг гаргаж яамын ШУТЗ-д танилцуулахад бэлэн болсон байна.

---оОо---